



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ
СУРГУУЛИЙН ХАРЬЯА
ТЕХНОЛОГИЙН КОЛЛЕЖИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/26

Улаанбаатар хот

“Оюутны зөвлөл, клубүүдийн үйл
ажиллагааг дэмжих журам” батлах тухай

ШУТИС-ийн харьяа Технологийн коллежийн дүрмийн 4.10.14, 4.10.15 дахь заалтууд, ШУТИС-ийн харьяа Технологийн коллежийн 2025 оны 02 дугаар сарын 25-ны захирлын зөвлөлийн хурал, 2025 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн байгууллагын хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. ШУТИС-ийн харьяа Технологийн коллежийн “Оюутны зөвлөл, клубүүдийн үйл ажиллагааг дэмжих журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Журмыг нийт оюутан, багш ажилтнуудад танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг нийгмийн ажилтан (Д.Цогзолмаа)-д үүрэг болгосугай.
3. Энэхүү журмыг 2025-2026 оны хичээлийн жилээс эхлэн мөрдсүгэй.


ЗАХИРАЛ



Д.ДУЛМАА

ШУТИС-ийн харьяа Технологийн коллежийн захирлын 2025 оны .04.
дүгээр сарын .10.-ны өдрийн 1/26 дугаар тушаалтын хавсралт



	ОЮУТНЫ ЗӨВЛӨЛ, КЛУБУУДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ ЖУРАМ	Эхний хэвдэлт	2025.04.10
		Өөрчилсөн огноо	
		Өөрчлөлтийн дугаар	

ОЮУТНЫ ЗӨВЛӨЛ, КЛУБУУДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ ЖУРАМ

Улаанбаатар 2025 он



НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Оюутны зөвлөл, клубүүд нь сургуулийн нийт суралцагчдын эрх ашгийг хамгаалах, хүсэл сонирхолд нийцсэн үйл ажиллагаа, нэгдсэн арга хэмжээг зохион байгуулахад сургуулийн зүгээс хамтран ажиллах, тэднийг дэмжихэд энэхүү журам мөрдөгдөнө.

ХОЁР. ОЮУТНЫ ЗӨВЛӨЛ, КЛУБИЙН БҮТЭЦ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1 Оюутны зөвлөлийн бүтэц үйл ажиллагаа

- 2.1.1 Оюутны зөвлөл нь 5-7 гишүүнтэй сайн дурын үндсэн дээр өөрсдийн санаачилгаар нэгдсэн нэгдэл байна. Оюутны зөвлөлийн бүрэлдэхүүний сургуулийн захирлын тушаалаар баталгаажуулна.
- 2.1.2 Оюутны зөвлөл нь тодорхой ажлын төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг зохион байгуулна.
- 2.1.3 Оюутны зөвлөл нь ажлын төлөвлөгөөг сургуулийн нийгмийн ажилтнаар баталгаажуулж сургалтын нэгдсэн хуанлид тусгаж цаг хугацааг дагаж мөрдөнө.
- 2.1.4 Оюутны зөвлөл нь оюутнуудаас жилд 1-2 удаа үйл ажиллагааны үр дүн болон шинэ ямар ажил хийх шаардлагатай байгаа талаар санал асуулга тогтмол авах
- 2.1.5 Оюутны зөвлөл нь оюутнуудыг үйл ажиллагаанд татан оролцуулахад сургуулийн удирдлага, ангийн багш нартай хамтран ажиллах

2.2 Оюутны клубүүдийн бүтэц, үйл ажиллагаа

- 2.2.1 Оюутны санаачилгаар бий болсон клубүүд нь мэргэжлийн, мэргэжлийн бус гэсэн чиглэлээр оюутны оролцоо, идэвхийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулна.
- 2.2.2 Мэргэжлийн клубүүд зөвлөх багштай байна.
- 2.2.3 Клубүүдийн гишүүнчлэл нээлттэй байна.
- 2.2.4 Клубүүд нь сургуулийн нэрийн өмнөөс уралдаан тэмцээнд оролцох асуудал нээлттэй явагдана.
- 2.2.5 Клубүүд нь өөрсдийн санаачилгаар шинэ төсөл хөтөлбөр хэрэгжүүлэн оюутан сурагчдыг хамарсан арга хэмжээг зохион байгуулах боломжтой.

ГУРАВ. СУРГУУЛИЙН ЗҮГЭЭС ОЮУТНЫ ЗӨВЛӨЛ, КЛУБИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ

- 3.1 Оюутны зөвлөл, клуб нь ажлын төлөвлөгөөний дагуу ажлыг цаг хугацаанд нь хийж гүйцэтгэхэд нийгмийн ажилтан, сургалтын алба, тэнхим нэгжүүд дэмжин хамтран ажиллана.
- 3.2 Оюутны зөвлөл, клуб нь үйл ажиллагааг төлөвлөгөөний дагуу болон шаардлагатай үед тодорхой албан бичиг хүсэлтийг үндэслэн төсөв авах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх
- 3.3 Оюутны зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих үүднээс 7-14 хоногт 1 удаа тогтсон цаг хугацаанд болон түүнээс дээш хугацаанд шаардлагатай үед хуралдах анги танхимаар хангаж өгөх

ШУТИС-ийн харьяа Технологийн коллежийн захирлын 2025 оны
04 дүгээр сарын 10-ны өдрийн А/26 дугаар тушаалын хавсралт



- 3.4 Клубүүдийн үйл ажиллагааг дэмжих үүднээс тогтсон хуваарийн дагуу анги танхимын хүрэлцээг харгалзан дэмжинэ.
- 3.5 Оюутны зөвлөл, клубийн шинэ санал, санаачилгыг судлан дэмжих, хамтран ажиллах

ДӨРӨВ. ОЮУТНЫ ЗӨВЛӨЛ, КЛУБИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЖ, ДҮГНЭХ

- 4.1 Оюутны зөвлөл нь үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хийсэн ажлын тайланг сургуулийн удирдлага, багш нараас бүрдсэн комисст улирал тутамд танилцуулна.
- 4.2 Оюутны мэргэжлийн клубүүд хичээлийн жилийн эцэст мэргэжлийн клуб харьяалах тэнхимийн багш нарт, сайн дурын клуб нийгмийн ажилтан, оюутны зөвлөлд тайлангаа танилцуулна.
- 4.3 Тайланд ажилласан ажлын хэсэг хавсралтад заасан хүснэгтийн дагуу оюутны зөвлөлийн ажилтай танилцаж оюутны зөвлөлийн даргын ажилд үнэлгээ өгнө.
- 4.4 Оюутны зөвлөлийн дарга оюутны зөвлөлийн гишүүн тус бүрд үйл ажиллагааны идэвх, оролцоо санаачилгыг нь дүгнэн нийгмийн ажилтанд үнэлгээг өгнө.
- 4.5 Оюутны зөвлөлийн дарга, гишүүдийн ажлын үр дүн сургуулийн оюутнуудын оролцоо идэвхийн үзүүлэлт, үйл ажиллагааны чанар, сургуульд оруулсан хувь нэмэр санаачилгыг нь үндэслэн урамшуулах саналыг сургуулийн захирлын зөвлөлд нийгмийн ажилтан тавьж шийдвэрлүүлнэ.

ТАВ. ОЮУТНЫ ЗӨВЛӨЛ, КЛУБҮҮДИЙН УРАМШУУЛАЛ

- 5.1 Оюутны зөвлөл нь хийсэн ажлын тайлангаа жилд нэг удаа хичээлийн жилийн төгсгөлд танилцуулна. Оюутны зөвлөлийн дарга гишүүд тогтвортой, үр бүтээлтэй ажилласан тохиолдолд дараах урамшууллыг олгоно.
- 5.2 Оюутны зөвлөлийн даргын урамшуулал жилд сургалтын төлбөрийн 20% хүртэл хөнгөлөлт үзүүлэх
- 5.3 Оюутны зөвлөлийн гишүүдийн урамшуулал жилд сургалтын төлбөрөөс 5% хүртэл хөнгөлөлт үзүүлэх боломж олгоно.
- 5.4 Мэргэжлийн клубийн ахлагч нарт ажлын үр дүнгээс хамааруулан жилд сургалтын төлбөрийн 3% хүртэлх урамшуулал олгож болно.
- 5.5 Сайн дурын клубийн ахлагч нарт ажлын үр дүнгээс хамааруулан сургалтын төлбөрийн 2% хүртэлх урамшуулал олгож болно.

ЗУРГАА. ҮЙЛ АЖИЛЛАГААНД ИДЭВХТЭЙ ОРОЛЦСОН ШИЛДЭГ ОЮУТАН, ШИЛДЭГ АНГИЙН УРАМШУУЛАЛ

- 6.1 Сургуулийн болон оюутны зөвлөл, клубүүдийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон, өөрийнхөө сурах, хөгжих үйл ажиллагаанд идэвхтэй оролцож бусдыгаа манлайлсан шилдэг оюутныг ШУТИС-ийн харьяа ТК-ийн шилдэг оюутан шалгаруулах журмын дагуу шалгаруулж сургалтын төлбөрийн 10% хүртэл сургалтын төлбөрөөс хөнгөлнө.

